



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

20 20 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/653

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТӨБЗГ-2019/12.2.1.47 дугаар гэрээт Цогт сумын соёлын төвийн барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	М.Ууган-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Бат-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	М.Мандаххүү	-аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга
	Ж.Мөнхчимэг	-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	Ж.Лхамаа	-Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер
	Б.Хатанболд	-Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер
	Ц.Амарсанаа	-Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч
	Д.Даваасамбуу	-Мэргэжлийн хяналтын газрын харилцаа холбооны хяналтын улсын байцаагч

2.


Д.Отгонжаргал-Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч  
Б.Балдорж -Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.Бээжин -"Алтай-Улиастайн Эрчим Хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер  
Т.Сүхбаатар -Цогт сумын Засаг дарга  
Б.Дагиймаа -Цогт сумын Соёлын төвийн эрхлэгч  
А.Нарандэлгэр-"Барилга байгууламж" ХХК-ийн захирал

Ш.Болдбаатар -"Мөрөн-Алтай" ХХК-ийн захирал

2.Барилгын угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (М.Ууган-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгахыг Цогт сумын Засаг даргын Тамгын газар (Д.Эрхэмбаяр)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Цогт сумын Соёлын төвийн эрхлэгч Б.Дагиймаад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Боловсруулсан  
Хянасан  
Хүвч  
Огноо